

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ханд	Дугаар	L087
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Баянхутаг
Төрсөн газар	Баянхутаг сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Тогоотын шүтээн	Сүм хийдийн дугаар	ХЭБХ 057
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 25	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Баянхутаг сумын Тогоотын шүтээн

-Танай нутагт байсан хуучны сүм хийдийн тухай асууж ярилцъя.

Гавжийн хувилгааны шүтээн гэж их сайхан шүтээн байсан юм.

-Тогоотын шүтээн гэж үү?

Гавжийн хувилгааны шүтээн,

-Тогоотын шүтээн, Гавжийн хувилгааны шүтээн хоёр нь тус тусдаа юм уу?

Тийм өөр юм.

-Бяцханы хийд гэж байсан юм үү?

Тогоотын шүтээнээ Бяцханы хийд гэж байгаа юм. Бяцханы худгийн ард Тогоотын шүтээний суварга байгаа.

Гавжийн хувилгаан гэдэг чинь баригдаад явчихсан. Их сайн хүн байсан.Тэр дээд талд нь бурхан тахилтай. Том цагаан байшинтай тэндээ хурал номоо хурдаг. Юунд босгож байсан юм бэ мэдэхгүй, 3,4 овоотой.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

- Гавжийн хувилгааны шүтээн гэдэг хэр олон дугантай, хэдэн ламтай ямархуу хурал байсан бэ?

Сайн мэдэхгүй байна. Гавжийн хувилгааны чинь Хонин гага, Дүн гага гэж эгч дүү хоёр тэнд байсан. Хувилгаан ч өөрөө авгай хүүхэдгүй хүн байсан. Энэ халх голын дайн анх эхлэхэд л зүүн хойд талд улаан гэрэл тэнгэрт тултал хаддаг байлаа. 1938,39 оны үед.

-Гавжийн хувилгаан гэдэг хүн хэдэн онд таалал болсон юм бэ?

Хойшоо баригдаад явсан. Тэгээд алга болсон. Том лам нарыг би ч үзээгүй нүцгэн биеэр нь тэмээнд хүлээнд аваад явдаг байсан. Тэгээд өөрөөр нь нүхийг нь үхуулаад бууддаг байсан гэсэн. Би өөрөө үзээгүй. Амаа энэ тэр тэгж байсан.

- Гавжийн хувилгааны хийд нь хэдэн дугантай ямар хийд байсан юм бол? Сонссон юм байна уу?

Манай ах байсан бол сайн мэдэх байсан. Би худлаа хэлээд яах вэ. Сүхийн Дамдин гэж Мөрөнд байдаг өвгөн байдаг. Энэ Үлгэрийн далай энэ тэрийг түж бичиж байдаг. Тэр сайн мэдэх байх.